



ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ  
УХААНЫ ИХ СУРГУУЛЬД

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.17 № 02/11 ЧАГ-САГ/2014/110/СТА-143

Зөрчил арилгуулах тухай

ЭМШУИС-ийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийх явцад тус байгууллага нь хувь хүний орлогын албан татвар ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй дараах зөрчил илэрлээ.

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.2-д "урлагийн тогтолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн шагналын орлогын дүнгээр татвар ногдуулна" заасныг зөрчиж нүүр ам судлалын сургууль "THE FIX" хамтлагт олгосон тогтолтын төлбөрийн 600.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар **30,0** мянган төгрөгийг ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй байна.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15.3-д "Энэ хуулийн 15.1-д заасан шууд бус орлогыг ажил олгогчоос уг орлогыг олгохтой холбогдон гарсан зардлын дүнгээр тодорхойлно", 22.1.4" шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлолгын дүнгээр", 23.1-д "Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дунд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна" заалтыг зөрчиж ХХОАТ ногдуулаагүй **754,2** мянган төгрөг байна. /тооцоо хавсралт № 2/
- Хувь хүн иргэдээс худалдан авсан нийт 18,118.5 мянган төгрөгний бараа ажил үйлчилгээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1-д заасан "Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараах орлогод албан татвар ногдуулна", 8.1.2-д "үйл ажиллагааны орлогод" заалтыг зөрчиж **1,791,8** мянган төгрөгийн татвар ногдуулж төсөвт төвлөрүүлээгүй байна./тооцоо хавсралт № 4/
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх явцад хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" заалтыг зөрчиж гэрээт болон цагийн багш ажилтнуудын цагийн хөлсөнд дээрх хөнгөлөлтийг давхар эдлүүлсэнээс **574.0** мянган төгрөгийн татвар дутуу ногдуулсан байна. /тооцоо хавсралт № 5/

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийн боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих" гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-ыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

Дээрх хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, хувь хүний орлогын албан татвар ногдуулж, төсөвт төвлөрүүлээгүй 3,150.0 мянган төгрөгийн зөрчлийг бүрэн арилгаж, хариуг албан ёсоор 2014 оны 06-р сарын 30-ны дотор УАГ-ын Санхүүгийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захирал Г.Батбаатар, Санхүү эдийн засгийн газрын дарга Р.Дашжав нараас шаардаж байна.

ШИНЖЭЭЧ

Н.НЯМДАВАА